

**ЗАСАГ ДАРГА САЙД НАРТАЙ БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
НИЙЛҮҮЛЭЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ.**

2010.03.15

ДАРХАН-УУЛ АЙМАГ

№	АГЕНТЛАГУУД	ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ	
		ХУВЬ	ОНОО
Тэргүүн шадар сайдтай			
1	Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс	100,0	5
Шадар сайдтай			
2	Хүүхдийн төлөө хэлтэс	100,0	5
3	Онцгой байдлын газар	100,0	5
4	Мэргэжлийн хяналтын газар	100,0	5
Хууль зүй, дотоод хэргийн сайдтай			
5	Цагдаагийн газар	100,0	5
Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай			
6	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	95,0	4,75
7	Ус, цаг уур, орчны шинжилгээний алба	95,0	4,75
Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдтай			
8	Тээвэр, авто замын газар	100,0	5
9	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	100,0	5
Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдтай			
10	Боловсрол, соёлын газар	100,0	5
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдтай			
11	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс	90,0	4,5
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд			
12	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар	100,0	5
Эрүүл мэндийн сайд			
13	Эрүүл мэндийн газар	90,0	4,5
Батлан хамгаалахын сайд			
14	Цэргийн штаб	100,0	5
Статистикийн хороо			
15	Статистикийн хэлтэс	100,0	5
НИЙТ		98,0	4,9

ҮНЭЛГЭЭ НЭГТГЭСЭН:
ТЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАСАН:
ТЗУХ-ИЙН ДАРГА
ХШҮ-НИЙ ТАСГИЙН ДАРГА

Б. БАТБАЯР
Б. АРЪЯА
Д. ЖАРГАЛСАЙХАН

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА САЙД НАРТАЙ БАЙГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН
НИЙЛҮҮЛЭЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭНИЙ ТАЙЛАН.**

2010.03.15

ДАРХАН-УУЛ

1. СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС.

34 аж ахуйн нэгжид 65 стандарт борлуулж, 32 стандартаар үйлчилгээ үзүүлж, 23 үйлчилгээний газарт чанарын хяналтын талаар зөвлөгөө өгч, 12 үйлчилгээний газарт баталгаажуулалтын мэдэгдэл өгсөн. 33 аж ахуйн нэгжийн 80 технологийн заавар болон 32 байгууллагын стандартыг бүртгэж баталгаажуулав.

Хүнсний аюулгүй байдал, лабораторын дотоод хяналт сургалтанд 35 аж ахуйн нэгж байгууллагын 55 хүн хамрагдлаа.

64 ширхэг ажлын эталоныг баталгаажуулан, үүнтэй дүйцүүлэн 200 ширхэг туухай, 3 жинг баталгаажуулан үйл ажиллагаандаа ашиглалаа.

2. ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ХЭЛТЭС.

Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 452 хүүхдийн судалгааг гаргалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгааг гарган картжуулж тэдэнд чиглэсэн арга хэмжээг салбарын байгууллагуудтай хамтран зохион байгуулж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэмшүүлэх, эмчилгээ, тусламж үйлчилгээг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой байна.

Судалгаанд тулгуурлан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 167 хүүхдэд ХХҮХ, Хүүхдийн Төлөө Хэлтэс, хүмүүнлэгийн байгууллагууд хамтран 12.938.0 мянган төгрөг, 6400 долларын эмчилгээ, хувцасны зардлыг санхүүжүүллээ.

Хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлж, эрхийг хамгаалах чиглэлээр “Хүүхдийн хүмүүжил гэр бүлээс эхтэй” зөвлөгөөнийг аймагт 650 иргэдэд зохион байгуулж 9 шилдэг гэр бүлийг шалгаруулан сурталчиллаа. Уг арга хэмжээнд 6000 орчим хүүхэд, насанд хүрэгчдийг хамруулан Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 887,7 мянган төгрөг, Хүүхдийн төлөө хэлтсээс 615,4 мянган төгрөг зарцууллаа.

Улсын чанартай уралдаан тэмцээнд 174 хүүхдийг оролцуулнаас алтан медаль 86, мөнгөн медаль 28, хүрэл медаль 17 нийт 131 медалыг манай аймгийн хүүхдүүд авсан байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, хөгжүүлэх зэрэг бүхий л чиглэлд зохих арга хэмжээнүүдэд төрийн болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж хэвшлээ.

3. ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР.

Гамшигаас хамгаалах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр Дархан, Шарын гол, Орхон, Хонгор сум, 144 байгууллага, 36 мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Аймгийн гамшигаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж ОБЕГ-ын даргаар батлууллаа.

Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг Дархан, Шарын гол, Орхон, Хонгор сум, 944 байгууллагын хүрээнд шалган биелэлтийг тооцон үнэлгээ дүгнэлт өгч ажиллалаа.

Гамшигаас хамгаалах мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг боловсронгуй болгох зорилгоор тус байгууллагын холбоо мэдээллийн сүлжээг боловсронгуй болгох ажил хийгдэж,

гал унтраах ангиуд интернет болон дотоод сүлжээнд бүрэн холбогдож удирдлагын холбоо мэдээллийн шуурхай ажиллагааг хангалаа.

Хонгор сум, томоохон 8 аж ахуйн нэгж, байгууллагад гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгууллаа.

Тус байгууллагаас нийт 10638 айл өрхөд ГАУС үзлэг, шалгалт хийж, 38394 хүнд ухуулга сурталчилгаа хийж нийт 1940 зөрчил илрүүлэн, 399 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 1541 зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд гал түймрийн хэрэг 153 удаа гарч, 3-ийг цагдаагийн байгууллагад шилжүүлэн бусдыг нь 100% шийдвэрлэсэн. Гал түймрийн хэрэг өнгөрсөн онтой харьцуулбал 10.9%, хохирол 22,1%-иар буурсан. Ой хээрийн түймэр 2009 онд 12 удаа гарч үүнээс 5 хэргийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Гал түймрийн тоо өнгөрсөн онтой харьцуулбал 58,3%-иар өсч, хохирол 9 дахин буурсан байна.

Тус газар нь 2009 онд төрийн сангаас 913124,8 мянган төгрөг, ДДЦС-аас 6986,1 мянган төгрөг бүгд 920110,0 мянган төгрөгийн санхүүжилт авч хуваарийн дагуу зарцуулсан.

4. МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР.

Салбарын хуулиудын уялдаа холбоог сайжруулах, холбогдох стандартуудыг шинэчлэх зорилтын хүрээнд

1. мал эмнэлгийн хяналтын чиглэлээр 2
2. Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналтын чиглэлээр 1
3. Худалдааны хяналтын чиглэлээр 1
4. Боловсролын хяналтын чиглэлээр 1
5. Хүүхдийн эрүүл ахуй хяналтын чиглэлээр 1
6. Орчны эрүүл ахуй хяналтын чиглэлээр 1
7. Өргөх механизмын чиглэлээр 1
8. Авто тээврийн чиглэлээр 1
9. Хот байгуулалтын чиглэлээр 1 удаа хууль тогтоомж, мөрдөгдөж байгаа стандартуудад нийт 10 санал хүргүүллээ.

Гүйцэтгэлийн хяналт шалгалтын чиглэлээр 2009 онд давхардсан тоогоор нийт 8612 хяналт шалгалт хийгдсэний 5544 буюу 64,3 %-д гүйцэтгэлийн хяналт явуулж 8346 зөрчил илрүүлснээс 6952 зөрчил буюу 83.2-ийг засуулсан нь өмнөх оны гүйцэтгэлийн шалгалтаас 11.2 %-иар илүү үр дүндтэй байна.

Тус газарт 2009 онд иргэдээс 527 өргөдөл ирснээс хуулийн хугацаанд 497 буюу 77,2%-ийг шийдвэрлэж, бусдыг нь хуулийн хугацаанд шийдвэрлэхээр ажиллаж байна. Давхардсан тоогоор 787 удаа хяналт шалгалтыг дээд байгууллагын шийдвэрээр явууллаа.

Нийт аж ахуйн нэгж байгууллагуудаас 1043 санал, хүсэлт ирснээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн нь 1001 буюу 95,9%-ийг шийдвэрлэлээ.

5. ЦАГДААГИЙН ГАЗАР.

Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох ажлыг эрчимжүүлж, илрүүлэлтэнд ахиц гаргах зорилтыг амжилттай хэрэгжүүлж, нийт гэмт хэргийн илрүүлэлт 69,5%-д хүрч ноднингийн мөн үеэс 19,5 хувиар, хүнд, онц хүнд хэргийн илрүүлэлтийг 100 %-д хүргэлээ.

Хөнгөн хэргийн илрүүлэлт 63,8 %-тай, урьд оны мөн үеэс 2,5%-иар, хүндэвтэр хэргийн илрүүлэлт 61 %- тай урьд оны мөн үеэс 16,1 %-иар тус тус өссөн үзүүлэлт гарсан бөгөөд эзэнгүй хэрэг жилийн эцэст 26 байгаа нь өмнөх оны мөн үеэс 32 хэргээр буюу 55,1 %-иар буурсан дүнтэй байна.

2009 онд тус цагдаагийн газраас эрүүгийн гэмт хэрэгт 3 албан хаагч холбогдон шалгагдсан нь урьд оны мөн үеэс 5 буюу 62,5 %, 45 албан хаагч сахилгын шийтгэл хүлээсэн нь 7 буюу 13,4 %-иар тус тус буурсан дүнтэй байна.

Тус цагдаагийн газарт тайлант хугацаанд гэмт хэргийн талаар 1428 гомдол, мэдээлэл хүрээн авч шийдвэрлэсэн нь 2008 оны мөн үеэс 40 гомдол мэдээлэл буюу 2,8%-иар өсч, хүлээн авсан бүх гомдол мэдээллийн 691 буюу 48,3%-д эрүүгийн хэрэг үүсгэн, 696 буюу 48,7 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналаар прокурорт хүргүүлэн 35 буюу 2,4 %-ийг харъяаллын дагуу шилжүүлэн шийдвэрлэсэн байна. Хүлээн авсан гомдол мэдээллийн 926 буюу 64,8 хувийг хуулийн анхны хугацаанд, 496 буюу 34,7%-ийг хуулийн хугацаанд шалган шийдвэрлэж, иргэдийг чирэгдүүлсэн гомдол, хуулийн хугацаа хэтрүүлсэн зөрчил дутагдал гараагүй байна.

2009 онд орон нутгийн төсвөөс 939,257,8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 963,515,1 мянган төгрөгийн зарлага санхүүжилт хийлээ. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн нийт хохирол 715,531,5 сая төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 20,1 %-иар буурсан байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 495,001,2 сая төгрөг байгаа нь урьд оны мөн үеэс 54,8 %-иар өссөн дүнтэй байна.

6. БОАЖГ

Аймгийн хэмжээнд байгалийн ус ашигласны төлбөрийн судалгааг авч үзвэл Орхон суманд 32 аж ахуйн нэгж, байгууллага, 923 иргэн, 4124,288 мянга, Хонгор суманд 5 аж ахуйн нэгж, байгууллага 3708270,0 мянган, Шарын гол суманд 14 аж ахуйн нэгж, байгууллага 26820,9 мянган төгрөг нийт 923 иргэн, 51 аж ахуйн нэгж, нийт 68027,888 мянган төгрөгний төлбөр төллөө.

2009 онд аймгийн хэмжээнд 3 булаг, шандын эхийг хашиж хамгаалсан ба энэхүү булгуудыг сонгохдоо зайлшгүй бүлгийн эхийг хашиж хамгаалах шаардлагатай, хүн малын хөлд талхлагдаж, ширгэж байгаа унд, ахуй хэрэгцээнд ашиглагддаг бүлгийн эхийг сонгож 3 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хамгаалалтын бүс тогтоон хашаажуулж, булгийн эхэнд 5-6 төрлийн төрьц суулган нийт 4500,0 мянган төгрөг зарцуулан тохижилтын ажлыг хийж сумдад бүрэн хүлээлгэн өглөө.

Энэ онд улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр 259 га, өөрийн хөрөнгөөр 70 га, нийт 329 га-д ойжуулалтын ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгж байгууллагуудыг урьд онд гүйцэтгэсэн ойжуулалтын үр дүн, туршлага зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг харгазан сонгон шалгаруулалтанд тэнцсэн 8 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, тарилт, ургалтын явцад хяналт тавьж ажилласаны үд дүнд нийт 329 га газарт 724,5 мянган ширхэг тарьц суулгацаар ойжуулалт хийлгээд байна. Ойжуулалтын амьдралтын хувь дундажаар 75-80 хувьтай байна.

7. УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА.

Тус алба нь 2009 онд цаг уур, хөдөө аж ахуйн цаг уур, ус судлал, урьдчилан мэдээлэх цаг уур, байгаль орчины хяналт шинжилгээ, багаж хэмжил зүй, систем сүлжээний ашиглалт зэрэг үйл ажиллагааны чиглэлүүдээр 164778,7 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоос 473,0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж ажиллалаа. Өр авлага гаргалгүй ажилласан.

8. ТЭЭВЭР, АВТО ЗАМЫН ГАЗАР.

Аймаг, сум, хот хооронд, хот доторхи нийтийн тээврийн үйлчилгээнд 400 гаруй тээврийн хэрэгсэл үйлчилж, давхардсан тоогоор 2424,5 мянган зорчигч тээвэрлэсэн байна.

Нийт зорчигчийн 96,5 % нь хотын доторхи тээвэр эзэлж байна.

Сүүлийн хагас жилд үзлэгт хамрагдаагүй үлдсэн 108 тээврийн хэрэгслийг оношилгоонд хамрууллаа. 9 удаа мэргэшсэн жолоочийн сургалт явуулж 235 жолоочийг сургаж мэргэшсэн жолоочийн үнэмлэх гардууллаа. Аймгийн хэмжээнд нэгдсэн болон түүвэр шалгалтыг 36 удаа зохион байгуулж 2321 тээврийн хэрэгсэл шалгаснаас 743 зөрчил илрүүлж, 1272 жолоочид хууль сурталчилан зөвлөгөө өгч, 280 жолоочийг 4940,0 мянган төгрөгөөр торгож зөрчлийг арилгууллаа.

9. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР.

2009 онд тус аймгийн газрын нэгдсэн сангийн үндсэн сангийн үндсэн ангиллыг шинэчлэн тогтоох, газрын тооллого, бүртгэл зураглалын ажлын хүнээнд өвөлжөө, хаваржааны газар Дархан сум 1375,9 га, Орхон сум 26850,5 га, Хонгор сум 86691,3 га, Шарын гол сум 3443,6 га, аймгийн хэмжээгээр 119431,17 га газар тоологдсон. 2009 онд газрын төлбөрт 365 сая төгрөг, дуудлага худалдааны орлогоор 68 сая төгрөг төвлөрүүлж, газрын төлбөрийн төлөвлөгөөг 100% биелүүллээ.

Газар эзэмших гэрээтэй:

1. Гэрээний хугацаа дууссан 38
2. Газар эзэмших гэрээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 28
3. Газар эзэмших гэрээ, гэрчилгээний болон эзэмшил газрын зөрчилтэй 40 иргэн, аж ахуйн нэгжийг илрүүлж, зөрчилийг арилгуулан, төлбөрийг барагдуулж ажиллалаа.

2009 онд аймгийн Засаг даргын захирамжаар өссөн дүнгээр 6969 иргэн газраа өмчилж аваад байна. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь улсын төсвөөс 91318,3 мянган төгрөг, төвлөрөх шилжүүлгээр 7832,7 мянган төгрөгийн, Газрын харилцаа, геодези зураг зүйн газраас хөрөнгийн санхүүжилтээр 3330,7 мянган төгрөгийн орлого авч хэвийн ажиллалаа.

10. БОЛОВСРОЛ, СОЁЛЫН ГАЗАР.

Салбарын үндсэн үзүүлэлт болох сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, үүний дотроос хамран сургалт цэвэр жингээр 66.6% хүрч хүрэх түвшингээс 1.6-13.0 %-иар илүү, Ерөнхий боловсролын хамран сургалт 99.8%, стандарт хангалт 100% байгаа нь улсын дундажтай харьцуулахад сайн үзүүлэлт юм.

Номын сан, музей, Залуучууд театр, хөдөөгийн соёлын төвүүдийн сургууль, цэцэрлэгүүдийг дэмжиж туслах талаар анхаарч ажиллалаа.

Тайлангийн хугацаанд өр авлагагүй ажиллалаа.

Боловсрол соёлын үйл ажиллагаанд 2009 онд 11124.2 сая төгрөг төсөвлөснөөс бодит гүйцэтгэлд 12103.5 сая төгрөгийг зарцууллаа.

11. ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС.

Мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлагдсан нийт 1907 иргэдийн 70 % нь байнгын ажлын байраар хангагдсан байна.

Нийтийг хамарсан 13 ажил зохион байгуулж түр ажлын байраар хангах үйл ажиллагааны үр дүнд хамрагдсан нийт иргэдийн 70,8 % буюу 405 эмзэг бүлгийн иргэд байлаа. Уг арга хэмжээнд 54989,5 мянган төгрөгийг зарцууллаа.

Мэргэжил олгох, давтан сургалтанд хамрагдсан 539 иргэний 372 суралцагч буюу 70,0 % нь ажлын байраар хангагдсан байна.

Шинээр 1051 ажлын байрыг бий болгосон буюу 68 хувь нь байнгын үйл ажиллагаа явуулж байна. Нийт 57 аж ахуйн нэгж, байгууллага, 188 иргэний үүсгэсэн 1552 ажлын байрыг шинээр бүртгэж ejob.mn веб сайтад бүртгэлээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох чиглэлээр амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрээр зохих эздэд нь сар бүр 5-25-ны хооронд цаг хугацаанд нь олгосон. Мөн “халамжийн үйлчилгээний менежер” программд иргэдийн мэдээллийг бүрэн оруулж аймгийн хэмжээнд баазтай болсон.

Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай 50 өрхийн 122 хүнийг орлогын эх үүсвэртэй болгох чиглэлээр төсөлд хамрууллаа. Ахмад настны нийгмийн хамгааллын хуулийн дагуу 55-60 наснаас дээш ахмадууд аймгийн хэмжээнд 7600 гаруй байдаг бөгөөд уг судалгааг үндэслэн хөнгөлөлт үйлчилгээнд бүрэн хамрууллаа. ,

Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 18812 өрхийн 30832 хүүхдийг хамруулж мөнгийг бүрэн олгосон. Нийтийг үйлчилгээний санхүүжилтэнд 7493736,4 төгрөг зарцууллаа.

12. ХХААЖДҮГ.

Газар тариалангийн чиглэлээр:

Нийт 1794 га усалгаатай талбайд үр тариа, төмс, хүнсний ногоо тариалж, 22177 тн ургац хураасан байна. Усалгаатай талбайг өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад 337,3 га-аар нэмэгдсэн дүнтэй байна.

Аймгийн хэмжээнд үр тариа 8531,5 га-гаас 9600,1 тн буюу гагаас дунджаар 11,3 цн төмс, 1024,1 га-гаас 13360 тн буюу га тутмаас дунджаар 130,5 цн, хүнсний ногоо 599,9 га-гаас 8549 тн буюу га тутмаас дунджаар 142,5 цн, малын тэжээл 42,5 тн, техникийн ургамал 560 тн ургац тус тус байгуулсан байна. Өнгөрсөн онтой харьцуулбал үр тариа 3049,6, төмс 2193,8, хүнсний ногоо 1061,9% малын тэжээл 18,5 тонноор тус тус нэмэгдэж, харин техникийн ургамал 750 тонноор буурч, аймгийн хүн амын физиологийн хэрэгцээт үр тарианы 72,7, хүнсний ногооны 140,2 хувийг, төмсөөр 3 дахин хангах боломжийг бүрдүүллээ.

Мал аж ахуйн чиглэлээр:

2009-2010 онд 4 сум 17 багийн 2.5 мянган өрхөд хонин толгойд шилжүүлсэнээр 744,0 мянган толгой малыг өвөлжүүлэх бэлтгэлийг зохион байгууллаа.

НҮБ-ийн ХХААБ-ын "Төвийн бүсийн тэжээлийн хангамж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд 2,4 сая төгрөгийн 5 төрлийн тэжээлийн үрийг олгон аймгийн хэмжээнд 101,3-га-д малын тэжээлийн ургамал тариалан 141,9 тонн буюу га-гаас 14 цн ургац хураан авч малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүллээ.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 405,7, паразит өвчнөөс сэргийлэх туулгалт, угаалга, боловсруулалтанд өссөн дүнгээр 819,0, мянган толгой малыг тус тус хамруулсанаар төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилт 105,0-130,0 хувь байна.

Бруцелёзын эрүүлжүүлэх шинжилгээ хийх ажлын хүрээнд уг өвчний голомт бүхий 235 өрхийн өвөлжөө, хашаанд голомт устгах ариутгал, халдваргүйжүүлэлтийг нэг удаа үнэ төлбөргүй, 711 өрхийн 311 мянган м.кв талбай бүхий 1320 өвөлжөө, хашаанд ариутгал халдваргүйтэл хийсэн байна.

ХХААЖДҮйлдвэрийн чиглэлээр улсын болон орон нутгийн төсвөөс 248.7, өөрийн үйл ажиллагааны орлогоос 1.4, нийт 250.1 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт хийлээ.

13. ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР.

2009 онд тус аймагт нялхасын эндэгдэл 9,1% буюу улсын дундажаас 10,8%-иар бага, 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл 12% буюу 10,9%-иар улсын дундажаас бага байна. 15349 оюутан, сурагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчлөл 7032 илэрсэнийг эрүүлжүүллээ. Нярайг хөхөөр хооллолт 78% буюу улсын дундажаас 40%-иар их, тураал 1,8% буюу улсын дундажаас 6,3%-иар багаслаа.

-0-1 насны хүүхдийн эндэгдэл 9,9% /улсын дундаж 19,4%/

-0-5 насны хүүхдийн эндэгдэл 12.7 % //улсын дундаж 22,6%/

-0-15 насны хүүхдийн эндэгдэл 6,9 % байна.

Аймгийн хэмжээнд 2009 оны эхний 11 сарын байдлаар 2396 эх төрж өмнөх оны мөн үеэс 433 төрөлтөөр нэмэгдсэн байна. Төрөлтийн хүндрэл урд оны мөн үеэс 2 тохиолдолоор буурсан байна. Энэ хугацаанд эхийн эндэгдэл гараагүй бөгөөд жирэмсний хяналт 82,0%, үүнээс эхний 3 сарын хяналт 81,9%, байлаа.

Аймгийн хэмжээнд нийт 263451 мянган хүн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Эдгээр хүмүүсээс онош тодруулахын тулд амжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур 358, хөдөө орон нутгийн 263, түр суугаа 92, отроор яваа 15 малчин, ЭМДаатгалгүй 830 хүнд бүгд 4621 онош тодруулах шинжилгээг үнэ төлбөргүй хийлээ.

Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нэр төрөл олширч цусны санд 227,950 л цус цуглуулж, Хөлдөөсөн шинэ сийвэн 58.405 литрийг үйлдвэрлэж, 186 донороор хүрээгээ нэмэгдүүлсэн байна.

2009 онд салбарын хэмжээнд 337 сая төгрөг төлөвлөлтөөс хасагдаж санхүүжигдсэн бөгөөд Эрүүл мэндийн газар нь өр авлагагүй ажиллалаа.

14. ЦЭРГИЙН ШТАБ

2009 онд чиг үүргийн хэрэгжүүлэн ажиллаж, 19 илт, 1 нууц баримт бичгийг хүрээн авч хэрэгжүүлэн ажиллалаа. Батлан хамгаалах талаархи Монгол улсын 5 хуулийн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 22 заалт, УИХ-ын тогтоолын 1 заалт, Ерөнхийлөгчийн зарлигийн 4 заалт, Засгийн газрын 9 тогтоолын 11 заалт, Батлах хамгаалахын сайдын байнга мөрдөх тушаалууд, ЗХЖШ-ын даргын холбогдох тушаалуудын заалтанд тус тус хяналт тавьж ажиллалаа. Цэргийн дүйцүүлэн хаах ажлыг зохион байгуулах тухай аймгийн ИТХТ-ийн хурлын тогтоол, шийдвэр-1, Цэргийн албатай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 16 захирамж, Засаг даргаас өгсөн 6 үүрэг даалгаварын хэрэгжилтийг зохион байгууллаа. Иргэдээс 146 санал хүсэлт, өргөдөл гомдол ирүүлснийг шуурхай барагдууллаа.

Хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчдын хяналтын тоо 100 % биелүүлсэн бөгөөд гараат цэргийн албаны дайчдын элсэлтийг Сэлэнгэ аймагт болсон Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчилах өдөрлөгийн үеэр урьдчилан зохион байгуулан 7 цэргийн үүрэгтэн, 2009 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар 7, 2 дугаар ээлжээр 5 нийт 12 гэрээт цэрэг элсүүлэн ЗХЖШ-аас өгсөн хяналтын тоог давуулан биелүүлсэн.

Цэргийн албанаас зайлсхийсэн, цэргийн шинэчилсэн тоо бүртгэлд шалтгаангүйгээр бүртгэгдээгүй иргэдэд хариуцлага тооцож, нийт 205 цэргийн үүрэгтэнд 2.031,000 төгрөгийн торгууль оногдууллаа.

Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг ЗХ-ний 330, 322 дугаар ангийн сургалтын материаллаг баазыг түшиглэн М-439, М-601, Х-601, П-575 мэргэжлээр тус бүр 10, бүгд 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн 40-ийг бэлтгэн явууллаа.

Дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан иргэдийн төлөх мөнгөн төлбөрийн хэмжээг бодитойгоор тогтоож, 2009 онд 6,702,494 төгрөгийн мөнгөн төлбөр төлөгдөөд байна.

266 иргэнд шинээр цэргийн үүрэгтний үнэмлэх олгож, шинэчилсэн тоо бүртгэлд бүртгэгдвэл зохих иргэдийн 78,2% нь хамрагдлаа. 452 цэргийн үүрэгтэн тус аймгаас өөр аймаг, хотуудад шилжин явж, 72 хүн өөр аймгаас шилжиж ирсэн байна.

15. СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2009 онд мөрдөх графикайг хүргэж, хэрэгжилтэнд нь бүртгэлээр хяналт тавин 15 хоног, сард танилцаж ажиллалаа.

Үнийн дэлгэрэнгүй буюу хэрэглээний 286 нэрийн бараа үйлчилгээний үнийн мэдээллийн катологийг гаргалаа. Мэдээ тайланг хүлээн авах, шалгах, нэгтгэх, кодлох шиферлэх ажлыг зорилт дэвшүүлэн ажилласнаар үр дүнд хүрч байна.

2009 онд графикаар өгөгдсөн бүх төрлийн Статистик мэдээллийг аймгийн 4 сум, 24 багийн хэмжээнд зохион байгуулан явуулж, нийт мэдээлэгчидтэй 100 % харилцан, тэдгээрийн мэдээллийг хугацаанд нь цуглуулах, шалгах, нэгтгэх ажил зохих ёсоор хийгдэж, аливаа зөрчилгүй 100% дамжууллаа.

2009 онд нийтдээ 4 сум, 284 аж ахуйн нэгж болон өрхөд статистик мэдээлэл тооллогын бодит байдал, чанарт мониторинг хийх шалгах, зөвлөгөө өгөх ажлыг хийлээ. Мөн багуудад статистик мэдээллээ өгөхөд хойрго ханддаг 34 аж ахуйн нэгжийг шаархай байдалд

хэвшүүлж, сум, баг дотроо 7135 иргэний бүртгэл давхардсаныг программаар илрүүлж зөрчлийг арилгууллаа.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ТЗУХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б. БАТБАЯР

ХЯНАСАН:
ТЗУХ-ИЙН ДАРГА
ХШҮТ-ИЙН ДАРГА

Б. АРЪЯА
Д. ЖАРГАЛСАЙХАН

ТАНИЛЦСАН:
АЗДТГ-ИЙН ДАРГА

Т. ГАНБОЛД